



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 29 өдөр

Дугаар A/48

Арвайхээр

Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, 34.1.11 дэх заалт, Засгийн газрын 2015 оны “Жагсаалт батлах тухай” 336 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”-ын 8.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссоос аймгийн өвөлжилтийн нөхцөлд хийсэн үнэлгээгээр 7 суманд эрсдэлийн түвшин их, 12 суманд дунд эрсдэлтэй гарсан байх тул зудын эрсдэлийг хохирол багатай даван туулах зорилгоор аймаг, сумын өвс тэжээлийн нөөцөд 5500 (таван мянга таван зуу) боодол нарийн өвсийг 71,500,000 (далан нэгэн сая таван зуун мянга) төгрөгөөр Мөнх урлал ХХК-иас худалдан авахыг зөвшөөрсүгэй.

2. Шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, өвс тэжээлийн чанар, баглаа боодол, гарал үүсэл зэрэгт хяналт тавьж, хуваарилалт хийж, гэрээ байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100109